



**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН АЛБАНЫ  
ТӨМӨР ЗАМ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 5/68

Улаанбаатар хот

**Нэг удаагийн буцалтгүй тусламж  
олгох тухай**

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.38 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.3.3 дахь хэсэг, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Буцалтгүй тусламж олгох” журам /код 932/-ийн 932.2.1 “а” дахь заалт, “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код 136/-ийн 136.5.2-ын “г” дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын ахмад настан Дашдэндэвийн Цэцгээ нь эрүүний үе, булчин, ясны үений хүнд хэлбэрийн үрэвсэл оноштойгоор Бүгд найрамдах Солонгос улсад хувийн зардлаар эмчлүүлэх болсон тул 100.000 /нэг зуун мянган/ төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжаар олгох 100.000 /нэг зуун мянган/ төгрөгийг зохих зардлаас зарцуулахыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Д.Отгондалай/-д даалгасугай.

3. Энэ тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд танилцуулсугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Д.БАТСАЙХАН